



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 04 өдөр

Дугаар A/100

Мөрөн сүм

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны өрөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, иргэн Лааганы Тэгшбаяр /РУ75061257/-ын хүсэлийг тус тус үндэслэн сумын аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/107 дугаар захирамжийн хавсралтаар Мөрөн сумын 8 дугаар баг 1 дүгээр хэсэгт байршилтай 6712008276 нэгж талбарын дугаартай 1217м², 6712008286 нэгж талбарын дугаартай 620м², 6712011839 нэгж талбарын дугаартай 760м² үйлчилгээтэй орон сууцны зориулалт бүхий 3 нэгж талбаруудын газруудыг нэгтгэж 2597м² гэж өөрчилж үлдсэн 25 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/38 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 3, 4, 5 дахь заалт, 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/107 дугаар захирамжийн хавсралтыг тус тус хүчингүй болгосугай.

3. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэн Л.Тэгшбаяртай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзүл) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН